



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 02 өдөр


Дугаар 02

Улаанбаатар хот


Г Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тусlamж,
үйлчилгээний чанарыг сайжруулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.3 заалтыг үндэслэн, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. "Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тусlamж, үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийх заавар"-ыг нэгдүгээр, "Хяналтын хуудасны загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал (Ш.Энхтөр)-д, Хүүхдийн анагаахын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга (Д.Малчинхүү) нарт даалгасугай.
3. Дэмжлэгт хяналтыг 6 сар тутамд тогтмол хийж хэвшүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (Я.Буянжаргал)-д үүрэг болгосугай.



08006



НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТ ХИЙХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү зааврыг хүүхдийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулахад ДЭМБ-аас улс орнуудад санал болгож буй үнэлгээний аргачлалыг үндэслэн боловсруулав.

Дэмжлэгт хяналтыг хийхдээ “хүүхдийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний өврийн лавлах” удирдамжийг ашиглана.

Дэмжлэгт хяналтын гол зорилго нь тусlamж, үйлчилгээний доголдлыг илрүүлж, зайлшгүй сайжруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Энэхүү зааварт нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хүүхдэд зайлшгүй шаардлагатай тусlamж, үйлчилгээний үзүүлэлтүүдийг тусгав. Зайлшгүй шаардлагатай тусlamж, үйлчилгээнд өвчтөнийг хүнд хөнгөнөөр эрэмбэлэн ангилах, нэн шаардлагатай эмийн хангамж, нярай болон бага насын хүүхдэд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ, яаралтай тусlamж ордог.

Дэмжлэгт хяналтыг хүүхдийн тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээний хүрээнд тусlamж, үйлчилгээний хоёр дахь шатлалын түвшинд нэг буюу хэд хэдэн эмнэлгийг хамруулан зохион байгуулж болно.

Хүүхдийн тусlamж, үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийхдээ дараах асуудлуудыг хамруулна.

1. Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тусlamжийн бүтэц, зохион байгуулалт;
2. Эм, багаж, хэрэгсэл, хүний нөөц зэрэг эмнэлгийн дэмжих алба;
3. Яаралтай тусlamж;
4. Хүүхдийн тасагт зонхиilon тохиолдох эмгэгүүдийн эмнэл зүйн тусlamж, үйлчилгээ. Үүнд:
 - Ханиалга ба амьсгал саадтай болох, хатгалгаа;



- Суулгалт;
 - Халууралт;
 - Хүнд тураал;
 - Нярайн асаргаа, эмчилгээ;
 - Төрөх үеийн нярайн тусламж;
 - Өвчтэй нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ;
5. Өвчтөнийг тогтмол хянах үйл ажиллагаа (хяналтын хуудас);
 6. Тэнхрүүлэх эмчилгээ (хооллох, шингэн нөхөх, тоглуулах гэх мэт);
 7. Хүүхдийг эмнэлгээс гаргах, зөвлөгөө өгөх, хяналтанд шилжүүлэх;
 8. Эх, хүүхдэд ээлтэй үйлчилгээ;
 9. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж;
 10. Тодорхой хугацааны дараа хүүхдийн тусламж, үйлчилгээнд гарах эерэг өөрчлөлтийг дахин хянаж баталгаажуулна.
 11. Дэмжлэгт хяналтыг хийхдээ хяналтын хуудсуудыг ашиглана.
 12. Мэдээллийг цуглувлан нэгтгэж, дүгнэсний дараа эмнэлгийн удирдлагатай уулзаж, үр дүнгээ товч танилцуулна.
 13. Тухайн эмнэлгийн хүүхдийн тусламж, үйлчилгээг сайжруулах төлөвлөгөөг боловсруулна.

Хоёр. Дэмжлэгт хяналт хийх баг

- 2.1. Дэмжлэгт хяналтыг Эрүүл мэндийн байгууллагын чанарын алба удирдан зохион байгуулна.
- 2.2. Дэмжлэгт хяналт хийх багийг хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгүүдийн менежментийн талаар тодорхой мэдлэгтэй, асуудалд олон ургалч үзлээр хандах чадвар бүхий, харилцан нэгнээ нөхөж чадах мэргэжилтнүүдээс бүрдүүлнэ. Үүнд:

- хүүхдийн эмч;
- ерөнхий мэргэжлийн эмч болон тухайн эмнэлэгтэй ижил төстэй эмнэлэгт ажилладаг эмч нар;
- хүүхдийн сувилагч;
- эмчилгээ эрхэлсэн орлогч гэх мэт

2.3. Дэмжлэгт хяналтын багийг тухайн эмнэлэг дотроосоо болон бусад байгууллагын ажилтнуудыг оролцуулан бүрдүүлнэ.


Гурав. Хяналтын хуудас

3.1. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хүүхдэд үзүүлэх тусlamж, үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийхэд төрөл бүрийн асуумж бүхий хяналтын хуудсуудыг ашиглана. Үүнд:

- Эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтын талаар тийм, үгүй гэсэн хариулт бүхий товч асуумж бүхий хяналтын хуудас;
- Эмнэлэгт ажиглалт хийсэн тэмдэглэл;
- Ажилтан, ажилчдаас ярилцлага авах хуудас;
- Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт бүхий хяналтын хуудас;
- Зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгслийн жагсаалт бүхий хяналтын хуудас;
- Эмчилгээ, үйлчилгээг батлагдсан стандарт, удирдамжийн дагуу хийж байгаа эсэхийг баталгаажуулах асуумж бүхий хяналтын хуудасууд;

Дөрөв. Дэмжлэгт хяналтын багийн сургалт

- 4.1. Дэмжлэгт хяналт хийх багийн сургалтыг зохион байгуулна.
- 4.2. Дэмжлэгт хяналт хийх баг нь хяналт хийх заавар, хяналтын хуудас, "Хүүхдийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний өврийн лавлах" хэмээх удирдамжтай бүрэн танилцаж тодорхой мэдлэгтэй болсон байна.
- 4.3 Дэмжлэгт хяналт хийх баг нь хяналтын хуудастай ажиллаж сурах зорилгоор тасагт дадлага хийж, хяналтын онооны талаар зөвшилцөх арга барилыг эзэмшинэ.
- 4.4. Хяналтын хуудас нь тайлбар, тэмдэглэл хөтлөх зйтай байна. Нэмэлт мэдээллийн эх сурвалжийн (өвчний түүх, ажилчидтай хийсэн ярилцлага, ажиглалт гэх мэт) талаар тодорхой бичнэ.
- 4.5. Цуглуулсан мэдээллийг тодотгон, бүлэг тус бүрээр хяналтын хуудасны хүснэгтэнд нэгтгэж, стандарт удирдамжийн шалгуурт тулгуурлан оноогоор дүгнэнэ.



4.6. Эцэст нь дээрх мэдээллийг хяналтын нэгдсэн хүснэгтэд оруулж, бүлэг тус бүрээр нийлбэр оноог гаргана.

4.7. Оноог өгөхдөө 5-аас 1 оноо өгнө. Үүнд:

- Эмчилгээ, оношлогоо, ажилбар нь удирдамж, стандартын дагуу байвал 5 оноо;
- Бага зэрэг сайжруулах шаардлагатай бол 4 оноо;
- Нилээд асуудлыг сайжруулах шаардлагатай бол 3 оноо;
- Ихэнх асуудлыг шинэчлэх шаардлагатай бол 2 оноо;
- Тусlamж, үйлчилгээ нь шаардлага хангахгүй эсвэл амь насанд эрсдэлтэй бол 1 оноо өгнө.

Хяналтын нэгтгэсэн оноо (дугуйлах)	Сайн	Сайжруулах шаардлагатай				
	5	4	3	2	1	

4.8. "Хяналтын хуудас"-аас аль нэг бүлгийг хассан эсвэл өөрчилсөн бол хяналтын нэгтгэсэн онооны нийлбэр өөрчлөгднө гэдгийг анхаарах хэрэгтэй.

Тав. Мэдээллийн эх сурвалж

Дэмжлэгт хяналтанд шаардагдах мэдээллийг дараах эх сурвалжаас цуглуулна:

5.1. Тохиолдлыг ажиглах:

5.1.1. Эмнэлзүйн тохиолдлын хувьд өвчтэй хүүхдэд үзүүлж буй тусlamж, үйлчилгээг ажиглах нь мэдээллийн гол эх сурвалж болно.

5.1.2. Хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдэд тусlamж, үйлчилгээ хэрхэн үзүүлж байгаа талаар мэдээлэл цуглуулахын тулд хүүхдийн тасагт аль болох олон тохиолдлын ажиглалтыг хийнэ.

5.1.3. Ажиглагч нь эмнэлэгт шинээр ирсэн, хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдэд хяналт хийхдээ түүний эмчилгээнд хөндлөнгөөс оролцож болохгүй.

5.1.4. Тухайн тохиолдлоор эмнэлгийн ажилчидтай ярилцах, өвчний түүхэнд дүгнэлт хийх, эмчилгээний хуудсыг хянах, өвчтэй хүүхдийн сахиуртай ярилцлага хийхдээ залруулга хийж болно.



5.2. Бүртгэлийн бичиг баримт:


- 5.2.1. Эмчилгээний чанарын талаарх мэдээллийг эмнэлэгт хэвтэж байгаа болон эмнэлгээс гараад удаагүй байгаа хүүхдийн өвчний түүх, баримт бичгээс цуглуулна.
- 5.2.2. Шууд ажиглалт хийх өвчтний тоо цөөн бол өвчний түүхээс мэдээлэл цуглуулна. Жишээлбэл: эмнэлэгт төдийлөн тохиолдоод байдаггүй мэнэн зэрэг харьцангуй ховор, хүнд өвчний тохиолдол.

5.3. Ярилцлага:

- 5.3.1. Хүүхдэд хийж буй эмчилгээний талаар ямар санал бодолтой байгаа талаар тухайн эмнэлгийн ажилчид, өвчтэй хүүхдийн асран хамгаалагчидтай ярилцлага хийнэ.
- 5.3.2. Өвчтөнд авах арга хэмжээнд хяналт хийхэд хүүхдийн тоо хангалтгүй бол тохиолдол зохиож, эмчилгээ заалган, түүнд нь хяналт хийж болно.

5.4. Эмнэлгээр тойрч үзэх:

- 5.4.1. Эмнэлгийн бодит орчин, ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг ажиглах замаар мэдээлэл цуглуулна.
- 5.4.2. Зайлшгүй шаардлагатай эмийн бэлэн байдлыг шалгана;
- 5.4.3. Зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгслийн бэлэн байдлыг шалгана.
- 5.4.4. Мэс засал хийдэг эмнэлэгт хагалгааны өрөөгөөр орж хүүхдэд хэмжээгээр тохирох багаж, хэрэгслийн бэлэн байгааг шалгана.
- 5.4.5. Хүүхдэд тусlamж, үйлчилгээ үзүүлдэг бусад тасгаар явж үзнэ.
- 5.4.6. Эргэлзээтэй тохиолдолд эмнэлгийн удирдлага, ажилчид, өвчтэй хүүхдийн сахиураас авсан мэдээллийг давхар шалган, ярилцлагын үеэр магадлана.
- 5.4.7. Тухайн эмнэлэг хүүхдийн тусlamж, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах төлөвлөгөө боловсруулж байгаа бол мэдээллийг газар дээр нь шалгаж үзнэ.
- 5.4.8. Тусlamж, үйлчилгээний чанарын талаар асуумж бүхий, хяналтын хуудсанд цуглуулсан мэдээллийг эмнэлэг дээр хийх ажиглалтаар давхар баталгаажуулна.



Зургаа. Дэмжлэгт хяналт хийх

- 6.1. Дэмжлэгт хяналт хийхэд ажлын хоёр өдөр шаардагдах бөгөөд орой, шөнийн цагаар ч ажиллах шаардлага гарч болно.
- 6.2. Дэмжлэгт хяналт зохион байгуулахаас өмнө эмнэлгийн удирдлагад мэдэгдэж, зөвшөөрөл авсан байх ёстой.
- 6.3. Асуумжууд бүхий хяналтын хуудсыг урьдчилан явуулна.
- 6.4. Дэмжлэгт хяналт хийх баг ирэхээс өмнө эмнэлгийн удирдлага шаардагдах мэдээллийг бэлэн болгосон байна.

6.5 Эхний өдөр:


- 6.5.1. Дэмжлэгт хяналтын баг нь хяналт хийх өдрийн өглөө эмнэлэг дээр ирсэн байна.
- 6.5.2. Дэмжлэгт хяналтыг долоо хоногийн ажлын ямар ч өдөр хийж болно.
- 6.5.3. Дэмжлэгт хяналтыг хийх эхний болон сүүлийн өдөр эмнэлгийн удирдлага, тасгийн эрхлэгч, ажилчидтай уулзалт зохион байгуулна.

6.6 Танилцуулах уулзалт:

- 6.6.1. Уулзалтын үеэр дэмжлэгт хяналтын зорилго, үйл явцыг танилцуулж, хүүхдийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад туслах зорилготой гэдгийг тайлбарлана.
- 6.6.2. Ажилчдаас өдөр тутмын үйл ажиллагааны талаар ярилцлага авч, аль болох олон хэвтэн эмчлүүлж байгаа ба шинээр хэвтэх хүүхдэд ажиглалт хийнэ гэдгийг тайлбарлана.
- 6.6.3. Уулзалтыг эртнээс товлож, холбогдох хүмүүсийн оролцоог бүрдүүлэхэд онцгой анхаарна.

6.7 Эмнэлэг дээр:

- 6.7.1. Хяналтыг эмнэлэг дотор тойрч үзэхээс эхэлнэ.
- 6.7.3. Тухайн эмнэлэгийн төрөх тасаг, нярайн хэсэг, эрчимт эмчилгээний тасаг, хүүхдийг хэвтүүлэн эмчилдэг мэс засал, халдварт, яаралтай тусламжийн тасаг, амбулатори, эмийн сан, лаборатори, цусны банк, дурс оношилгоо зэрэг бүх тасаг, нэгжээр тойрч үзнэ.



6.7.4. Үүний дараа ажиглалт хийхэд анхаарч, тус эмнэлэгт шинээр ирсэн, хэвтсэн хүүхдүүдэд тусlamж, үйлчилгээ үзүүлж буй байдлыг дагаж хяналт хийнэ.

6.7.5. Дэмжлэгт хяналт хийх явцдаа хөндлөнгөөс заавар өгч, эмчилгээ, үйлчилгээнд оролцож хэрхэвч болохгүй.

6.7.6. Ажиглалт хийхэд чөлөөтэй, ажилчид, өвчтэй хүүхдийн сахиураас ярилцлага авахад ямар ч саадгүй байна.

6.8. Хоёр дахь өдөр:

6.8.1. Эмнэлгийн ажилчид, өвчтэй хүүхдийн асран хамгаалагчдаас ярилцлага авах, тохиолдлын ажиглалт хийх, өвчний түүхтэй танилцах ажлыг үргэлжлүүлнэ.

6.8.2. Мэдээллийг цуглуулахдаа салбар, нэгж бүрийг хамруулах ба хяналтын хуудсаа эргэн хянаж, асуудал орхигдсон эсэхийг тогтмол шалгана.

6.8.3. Зарим нэг тодорхой ажлыг гүйцэтгэхэд бүлгээр хуваагдаж ажиллах ба үе багаараа цугларч үр дүнг урьдчилан хэлэлцэнэ.

6.8.4. Үр дүнг танилцуулах уулзалтанд чамбай бэлдэж, хяналтын явцад цуглуулсан мэдээллүүдийг эмнэлгийн удирдлагад танилцуулах зорилгоор хүснэгтэнд нэгтгэнэ.


6.9. Үр дүнг танилцуулах уулзалт:

6.9.1. Энэ уулзалтын үндсэн зорилго нь дэмжлэгт хяналтын үр дүнг хэлэлцүүлж, тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг шууд төлөвлөхөд оршино.

6.9.2. Дэмжлэгт хяналтын үр дүнг эмнэлгийн удирдлага, тасгийн эрхлэгчид, болон хяналтанд хамрагдсан бүх ажилтан ажилчдад танилцуулна.

6.9.3. Хамтарч ажилласанд тус эмнэлгийн ажилчдад талархал илэрхийлж, ололт амжилт, давуу талыг эхэлж дурьдсаны дараа доголдож буй асуудлыг хэлэлцэнэ.

6.9.4. Хаана ямар дутагдал байна, байдлыг өөрчлөхөд юу хийх ёстой вэ гэдгийг хүн бүрт танилцуулж ойлгуулна.



- 6.9.5. Дээрх дутагдал доголдол нь тухайн байгууллагын эндэгдлийн үзүүлэлтэд нөлөөлж байгаа эсэх үүнийг хэрхэн сайжруулах талаар хэлэлцэж, сайжруулах өөрчлөх шаардлагатай тэргүүлэх гурван асуудлыг тодорхойлж. яаралтай арга хэмжээний төлөвлөгөөг даруй боловсруулна.
- 6.9.6. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа **ямар асуудлыг, хэзээ, хэн** шийдвэрлэх талаар тодорхой тусган, шаардагдах зардлын эх үүсвэрийг тогтооно.
- 6.9.7. Тэргүүлэх асуудал тус бүрээр хариуцах хүмүүсийг томилно.
- 6.9.10. Санхүүгийн эх үүсвэр, хангамж, тоног төхөөрөмж, сургалтын хэрэгцээ болон бусад техникийн асуудлыг тодорхойлон, явцын хяналт хийх хугацааг товлоно.

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 01 сарын 02 өдрийн
02 тоот тушаалын 1 дүгээр
хавсралт

Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тусlamж, үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийх заавар

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү зааврыг хүүхдийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулахад ДЭМБ-аас улс орнуудад санал болгож буй үнэлгээний аргачлалыг үндэслэн боловсруулав.

Дэмжлэгт хяналтыг хийхдээ “хүүхдийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний өврийн лавлах” удирдамжийг ашиглана.

Дэмжлэгт хяналтын гол зорилго нь тусlamж, үйлчилгээний доголдлыг илрүүлж, зайлшгүй сайжруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Энэхүү зааварт нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хүүхдэд зайлшгүй шаардлагатай тусlamж, үйлчилгээний үзүүлэлтүүдийг тусгав. Зайлшгүй шаардлагатай тусlamж, үйлчилгээнд өвчтөнийг хүнд хөнгөнөөр эрэмбэлэн ангилах, нэн шаардлагатай эмийн хангамж, нярай болон бага насны хүүхдэд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ, яаралтай тусlamж ордог.

Дэмжлэгт хяналтыг хүүхдийн тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээний хүрээнд тусlamж, үйлчилгээний хоёр дахь шатлалын түвшинд нэг буюу хэд хэдэн эмнэлгийг хамруулан зохион байгуулж болно.

Хүүхдийн тусlamж, үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийхдээ дараах асуудлуудыг хамруулна.

1. Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тусlamжийн бүтэц, зохион байгуулалт;
2. Эм, багаж, хэрэгсэл, хүний нөөц зэрэг эмнэлгийн дэмжих алба;
3. Яаралтай тусlamж;
4. Хүүхдийн тасагт зонхиlon тохиолдох эмгэгүүдийн эмнэл зүйн тусlamж, үйлчилгээ. Үүнд:
 - Ханиалга ба амьсгал саадтай болох, хатгалгаа;

Эрүүл мэндийн сайдын
оны 01 сарын 02 өдрийн
02 тоот тушаалын 2 дугаар
хавсралт

ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

1. Эмнэлгийн талаарх ерөнхий мэдээлэл

Эх сурвалж: Эмнэлгээр явж ажиглалт хийх, эмнэлгийн дарга, эсвэл тасгийн эрхлэгч, ажилчидтай уулзаж ярилцах.

Зааварчилгаа: Цаг, тооны талаарх мэдээллийг цуглуул.

Үнэлгээ хийсэн он, сар, өдөр/...../.....
 Ярилцлага өгсөн хүмүүсийн нэр
 Эмнэлгийн байгууллагын нэр
 Аймаг, дүүрэг
 Эмнэлгийн байгууллагын төрөл.....

1.1 Эмнэлгийн зохион байгуулалт

Тусдаа амбулатортой юу? Тийм Үгүй

Тайлбар:

Хүүхдийн амбулатори нь том хүнийхээс тустай юу? Тийм Үгүй

Тайлбар
 Хүүхдийн амбулаторийн ажил хэдэн цагаас эхэлдэг вэ?цаг

Хүүхдийн амбулатори хэдэн цагт хаадаг вэ?цаг

Яаралтай тусlamжийн тасаг тусдаа байдаг уу? Тийм Үгүй

Энэ тасаг нь 24 цагаар ажилладаг уу? Тийм Үгүй

Үгүй бол хэдэн цагаар ажилладаг вэ?
 Тус эмнэлэгт хүүхдийн тасаг ажилладаг уу? Тийм Үгүй

Тийм бол хэдэн ортой вэ?
 Тус эмнэлэгт нярай хүүхэд авдаг тасаг эсвэл өрөө бий юу? Тийм Үгүй

Тийм бол хэдэн ортой вэ?
 Тус эмнэлэгт нярай хүүхэд авдаг тасаг эсвэл өрөө бий юу? Тийм Үгүй

Тус эмнэлэгт халдвартай хүүхэд авах тасаг эсвэл өрөө бий юу (тусгаарлах өрөө)?

Тийм бол хэдэн ортой вэ?

Тийм бол, том хүнийхээс тусдаа юу?

Тайлбар:.....



Тийм

Үгүй

Тийм

Үгүй

Мэс заслын эмгэгтэй хүүхдийг хаана авдаг вэ?

Тайлбар:.....

Тусгай эсвэл эрчимт эмчилгээ шаардагдах хүүхдийг хаана авдаг вэ?

Тайлбар:.....

Хамгийн хүнд хүүхдүүдийг хяналт сайтай хэсэгт авдаг уу? (сувилагчийн постонд ойр)

Тайлбар:.....

Хүүхдийн тасагт мэргэжлийн сувилагч 24 цагаар ажилладаг уу?

Тайлбар:.....

2. Эмнэлгийн дэмжих үйлчилгээ

Эх сурвалж: Эмнэлэгт очихдоо, мөн ажилчидтай ярилцлага хийх үеэр цуглуулж болно. Тохирох нүдэнд тэмдэглэл хий. Хангамж тогтвортгүй бол тайлбарлана.

	Яаралтай тусlamжийн тасаг/ Амбулатор	Хүүхдийн тасаг	Тайлбар
Байнгын цахилгаан хангамжтай юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Цахилгаан тасарвал өөр эх үүсвэр бий юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Урсгал (крантны) устай юу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Үгүй бол: тухайн тасагт гар угаах ус бэлэн байх уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Саван эсвэл гар ариутгагч байх уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Зүү зэрэг хурц зүйл хаях хайрцаг, сав байх уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Вакцин, тариа хадгалах хөргөгч ажилладаг уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Эмнэлэг дотор санал гомдлын дэвтэр/хайрцаг эсвэл албан ёсоор эмнэлгийн захирагаанд хандах боломж бий уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

2.1 Эмнэлгийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд

Эх сурвалж: Өдөр тутмын статистик үзүүлэлтүүд. Эмнэлэгт очихдоо эмнэлгийн захираганаас цуглуулна. Статистик үзүүлэлтээс ашиглаж, шаардлагатай бол төрөл төрлөөр нь, жишээ нь насны бүлгээр, тохиргоо хийнэ.

2.1.1 Эмнэлгийн ачаалал

Жилд амбулаториор үзүүлсэн, яаралтай тусlamж авсан, эмнэлэгт хэвтсэн хүүхдийн тоог нас, насаар нь тэмдэглэ. Үүнд: эмнэлэгт ирэхэд нас барсан хүүхдийн тоо орохгүй.

Он: _____

	Амбулатори	Яаралтай тусlamж	Хэвтсэн
0 – 28 хоногтой	_____	_____	_____
1 - 12 сартай	_____	_____	_____
1 - 5 настай	_____	_____	_____
≥5 настай	_____	_____	_____
Нийт	_____	_____	_____

2.1.2 Эмнэлэгт хэвтэх

Амбулаторт үзүүлэх, яаралтай тусlamж авах, эмнэлэгт хэвтэх хамгийн түгээмэл 5 шалтгаан (онош)-ыг жагсaa.

	Амбулатори	Яаралтай тусlamж	Хэвтсэн
1.			
2.			
3.			
4.			
5.			



2.1.3 Хүүхдийн мэс засал

Эх сурвалж: Өдөр тутмын статистик үзүүлэлтүүд. Эмнэлэгт очихдоо эмнэлгийн захираганаас авна.

Хамгийн их хийгдэх мэс ажилбарын жагсаалт:

	Мэс ажилбар	Мэс ажилбарын тоо (жилээр)	Хийсэн эмчийн нэр
1.			
2.			
3.			
4.			
5.			

Хүүхдэд эдгээр мэс ажилбарыг хэр их хийдэг вэ?

	Өдөр тутам	Хааяа нэг	Огт хийдэггүй	Хийсэн эмч:	Өөр эмнэлэгт шилжсэн
Тээрхийн зүслэг					
Эвэрхий					
Ясны хугарал					
Арьс шилжүүлэн суулгах					
Мухар олгой зэрэг хэвлэлийн хөндийн мэс засал					
Буглаа нээх, цэвэрлэх					

2.2. Зайлшгүй шаардлагатай эм, багаж, хэрэгсэл.

Эх сурвалж: Эмнэлэгт очихдоо яаралтай тусlamж, хүүхдийн тасаг, эмийн сангаас цуглувна.

2.2.1 Зайлшгүй шаардлагатай эм

Орон нутагт олдоцтой эмийг заа. Хэрэв тухайн эмийг зөвхөн худалдаанаас авах боломжтой, хүүхдэд чөлөөтэй олгодоггүй бол тайлбар хийнэ. Доорх эмээс аль нь байгаа, хангамж нь тогтмол эсэх, хугацаа нь хэзээ дуусахыг лавла. Хугацаа нь дуусах дөхсөн эмийг түрүүж хэрэглэдэг эсэхийг тодруулна.

	Яаралтай тусламжийн тасаг	Хүүхдийн тасаг	Эмийн сан/худал даанд	Тайлбар
Глюкоз 30-50% (судсаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Глюкоз 10% (судсаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Глюкоз 5% (судсаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Натрий хлор (судсаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Рингер лактат (судсаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Эpineфрин (Адреналин) арьсан дор	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Кортикостероидууд (судсаар, уухаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Фуросемид (судсаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Таталтын эсрэг 1-р сонголтийн эм: *Диазепам/Паралдегид (булчинд, судсаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
*Фенобарбитал (булчинд, судсаар)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Антибиотикууд				
Бензил пенициллин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Амоксициллин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ампициллин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
*Цефалоспорин (3-р үе)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
*Хлорамфеникол	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Ципрофлоксацин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Гентамицин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Котrimоксазол	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Флуконазол	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Бусад эмүүд				
Амфотерицин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Дигоксин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Төмрийн бэлдмэл сироп	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Төмрийн бэлдмэл шахмал _____ мг	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Амин дэм-эрдэсийн холимог	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Витамин А уухаар	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Витамин К булчинд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
ШСД	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

2.2.2 Зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгсэл

Эх сурвалж: Эмнэлэгт очихдоо яаралтай тусlamж, хүүхдийн тасаг, эмийн сангаас цуглувна.

Дараах багаж, хэрэгслээс аль нь яаралтай тусlamж, хүүхдийн тасаг, эмийн сан, худалдаанд бэлэн байдаг вэ? Багаж, хэрэгслийг үзэж, цэвэр, хэвийн, аюулгүй ажиллагаатай эсэхийг нь шалгана. Мөн хэмжээ нь нялхас болон бусад настын хүүхдэд тохирох эсэхийг тодруулна.

	Яаралтай тусlamжийн тасаг	Хүүхдийн тасаг	Эмийн сан/худал даанд	Тайлбар
Сэхээн амьдруулах ширээ/хэсэг	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Босоо гэрэлтүүлэгч	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Чихний дуран	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хүүхдийн жин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Өндөр хэмжигч (насанд нь тохирсон хэвтээ эсвэл босоо хэмжигч)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Чагнуур	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Халууны шил	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Дулааны эх үүсвэр	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хүчил төрөгч	Хүчил төрөгчийн баллон	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



	Хүчил төрөгч өтгөрүүлэгч	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Төвийн хангамжаас	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хүчилтөрөгчийн хийн урсгал хэмжигч	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хүчилтөрөгч өгөх хэрэгсэл	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Хэрэглэж буй багаж төхөөрөмж	Хамрын ац гуурс <input type="checkbox"/> Гуурс <input type="checkbox"/> Хошуувч <input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Сэхээн амьдруулах амьсгалын хүүдий (өөрөө хийлгэгддэг)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Хошуувч	<input type="checkbox"/> Нярай, бага насны <input type="checkbox"/> Хүүхдийн <input type="checkbox"/> Том хүний	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Автомат шахуургын шприц (хүүхдэд тохирох хэмжээтэй)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Эрвээхэй эсвэл хүүхдийн үян зүү (21-25)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хамар-ходоодны хаймсуур хүүхдэд тохирох (5,8,12)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Ясанд хатгалт, тария хийх хэрэгсэл	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Соруулах төхөөрөмж	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Цээжний гуурс	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Сальбутамол цацагч	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Цацагчийн төрөл	<input type="checkbox"/> цахилгаан <input type="checkbox"/> хүчил төрөгчөөр ажиллах <input type="checkbox"/> хөл шахуургатай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
	Сальбутамолыг тунлаж цацах хошуувч бүхий түгээгч	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		


2.2.3 Зайлшгүй шаардлагатай эм, багаж, хэрэгслийн стандарт

- Зайлшгүй шаардлагатай эм жагсаалтын дагуу бэлэн байна.
- Зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгсэл ажиллагаатай, бэлэн байна.
- Хүүхдэд тохиорх хэмжээтэй мэдээгүйжүүлэх багаж, хэрэгсэл ажиллагаатай, бэлэн байна.

Анхаарах: Дээрх хүснэгтүүдийг харж бөглөнө.

Стандарт болон шалгуурууд	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
Зайлшгүй шаардлагатай эмийн бэлэн байдал			
Зайлшгүй шаардлагатай эмийн бэлэн жагсаалт. Жагсаалтанд орсон эмийг зонхилон тохиолдох өвчний эмчилгээнд хэрэглэх боломжтой. Зайлшгүй шаардлагатай эм яаралтай тусламж, хүүхдийн тасагт бэлэн байна. Хэрэглэх хугацаа нь дуусаагүй. Илүү удаан хадгалагдсан эмийг түрүүлж хэрэглэдэг.			
Зайлшгүй багаж, хэрэгслийн бэлэн байдал			
Зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгсэл шууд хэрэглэхэд бэлэн байна. Зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгсэл аюулгүй,			

ажиллагаатай байна.
Зайлшгүй шаардлагатай багаж,
хэрэгсэл хүүхдэд тохирох
хэмжээтэй байна.



Зайлшгүй шаардлагатай эм, багаж, хэрэгслийг нэгтгэсэн хүснэгт

	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
Зайлшгүй шаардлагатай эм бэлэн, хугацаа нь дуусах болоогүй, илүү удаан хадгалсныг түрүүлж хэрэглэдэг.			
Хүүхдэд тохирох хэмжээтэй мэдээгүйжүүлэх багаж, хэрэгсэл ажиллагаатай, бэлэн байна.			
Яаралтай тусламж, хүүхдийн тасгуудад нэн шаардлагатай багаж, хэрэгсэл бэлэн байна.			
Судсаар хийх зохих шингэнүүд бүгд байна.			

Зайлшгүй шаардлагатай эм, багаж, хэрэгслийн хангамжийн нэгтгэсэн оноо (дугуйлах)	Сайн	Сайжруулах шаардлагатай	5	4	3	2	1

2.3 Лаборатори

Эх сурвалж: Эмнэлэгт очиждоо лабораториор явж, түүний эрхлэгчтэй уулзахдаа цуглуулна.

Тус эмнэлэгт хийгдэж буй нэн шаардлагатай шинжилгээнээс аль болох олныг харж ажиглахыг хичээнэ. Дараах шинжилгээг хэр шуурхай хийж, хариу нь хэр түргэн гарч байна вэ? (Цусны сахар, Hb, PCV хагас цагийн дотор, бусад шинжилгээ 1-2 цаг). Боломжтой бол шинжилгээний хариу гарах хугацааг заа.

		Хийдэг	Хийдэггүй	Хариу гарах хугацаа	Тайлбар
Цусны сахар		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Гемоглобин		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		

Гематокрит (PCV)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Нугасны шингэнийг микроскопоор шинжлэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Шээсийг микроскопоор шинжлэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Шээсний дурдэг тест (альбумин, сахар, нитрит, лейкоцит, бусадыг заана уу)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
ХДХВ/ДОХ-ын серолог шинжилгээ	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Цусны бүлэг тодорхойлох, тохироо үзэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Билирубин	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
Сийвэнд ХДХВ эсвэл CD4-ийн хэмжээг үндэсний удирдамжийн дагуу тодорхойлох	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		

Лабораторийн нэн шаардлагатай шинжилгээ сорилуудыг стандартын дагуу найдвартай хийж, шинжилгээний хариуг түргэн хүргэдэг.

Стандарт болон шалгуурууд	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
Лабораторийн нэн шаардлагатай сорил шинжилгээ (цусны сахар, гемоглобин, гематокрит үзэх, нугасны шингэн ба шээсэнд эсийн бүтцийг харах, цусны бүлэг тодорхойлж, тохироо үзэх, ХДХВ-ын шинжилгээ)-г хүссэн цагтаа хийх боломжтой бөгөөд хариуг нь яаралтай тусламж, хүүхдийн тасагт цаг алдалгүй хүргэж өгдөг.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Нэн шаардлагатай шинжилгээ хийлгэхэд санхүүгийн бэрхшээлтэй тулгарахгүй байх (үнэгүй, эсвэл хүүхдэд тусгай өртгөөр үйлчлэх).	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Яаралтай тохиолдолд шинжилгээг түрүүлж хийдэг.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Лабораторийн тусламж, үйлчилгээний нэгтгэсэн оноо (дугуйлах)	Сайн	Сайжруулах
	5	4 3 2 1

3. Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж

3.1 Яаралтай өвчтөнд авах арга хэмжээ

Эх сурвалж: Яаралтай тусламжийн тасгаар явж, үйлчилгээ үзүүлэгч нартай уулзаж, ярилцлага авна.

Заавар: Яаралтай тохиолдлыг хаана, хэн хүлээн авдаг, эмч мэргэжилтнийг хэрхэн дууддаг, хүнд тохиолдолд хэн, хаана арга хэмжээ авдаг талаар асууна.

Мэс засал болон бусад яаралтай тохиолдлыг хаана хүлээн авдаг вэ?

.....

Яаралтай өвчтөнийг хүлээн авах загвар (Яаралтай тусламжийн тасагт шууд ирсэн тохиолдолд):

.....

Амбулаторийн нөхцөлд хүнд өвчтөнийг хэрхэн оношилж, арга хэмжээ авдаг вэ (жишээ нь: амбулаторт ердийн журмаар үзүүлсэн боловч хүнд өвчтэй тохиолдлууд)?
Өвчтөнг угтан дагуулах үйлчилгээний талаар.

.....

Хүнд өвчтэй хүүхдэд илүү анхаарах тогтолцоо байна уу (хүнд, хөнгөнөөр эрэмбэлэн ангилах уу)?

Тийм Үгүй

Тийм бол тайлбар хийнэ:

.....

Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх зорилгоор тоноглогдсон өрөө байна уу?

Тийм Үгүй

Тийм бол тайлбарлана:

.....
.....
.....

Хүндэвтэр хүүхдэд зөвлөгөө өгөх хэсэг гэж байна уу?

Тийм бол тайлбар хийнэ:

Тийм

Үгүй

Тийм Үгүй

Энэ нь шилжүүлэггүй хүүхдэд тусlamж үзүүлэх амбулаторийн хэсгээс тусдаа байна уу
(ХӨЦМ-ийн хэсэг)?

Тийм бол тайлбар хийнэ:

.....
.....
.....

Анхан шатны тусlamж, үйлчилгээний байгууллагаас шилжүүлэгтэй ирдэг үү?

Үгүй

хааяа

дандаа

Тайлбар:

.....
.....
.....

Хүүхдэд яаралтай арга хэмжээ авахад туслах зүйл (хананы үзүүлэн, хүснэгт) бэлэн байдаг уу?

Тийм Үгүй


Тийм бол, ямар арга хэмжээний талаар, хэр зохимжтой дүрсэлснийг тайлбарлана:

.....
.....
.....

3.2 Яаралтай тусlamж үзүүлэгчид

Үүнд яаралтай тусlamж үзүүлэх хүмүүс, тэдгээрийн ур чадвар орно.

Ажилтан	Ажлын цагаар Байдаг/бай даггүй Байдаг бол тоо	Ажлын бус цагаар Байдаг/бай даггүй Байдаг бол тоо	Яаралтай тохиолдолд үнэлгээ хийх/илрүү лэхэд сургагдсан Тийм/Үгүй	Яаралтай тохиолдолд арга хэмжээ авахад сургагдсан Тийм/Үгүй	Тайлбар
Үүдний харуул					

Бүртгэл хөтлөгч					
Ялган салгах сувилагч					
Сувилагч					
Туслах					
Эмнэлзүйн ажилтан					
Эмч					

3.3 Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусlamжийн бүтэц, зохион байгуулалт

Стандартууд

- Өвчтөнд маягт бүртгэл хөтлөхөөс өмнө “яаралтай шинж” байгаа эсэхийг шалгана.
- Яаралтай тусlamжийн тасаг нь зохих хэмжээнд тоноглогдсон, яаралтай тусlamжид өргөн хэрэглэгдэх нэн шаардлагатай эм, тариагаар хангагдсан байна.
- Мэргэшсэн эрүүл мэндийн ажилтан ялган, яаралтай үед, жишээ нь таталт, мэдрэл алдагдсан, шок, амьсгал хямралын үед удирдамжийн дагуу тусlamж үзүүлж чаддаг байна.

Стандарт болон шалгуурууд	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
Тасагт орж ирсэн даруйд нь хүүхдэд тулгамдсан байдлын шинжийг мөшгөн илрүүлнэ. Анхны үзлэг хийгдэж, арга хэмжээ авахаас өмнө эцэг эх нь дараалал хүлээж, бүртгүүлэх, төлбөр хийх зэрэг шаардлагагүй. Яаралтай тусlamжийн хүлээн авах хэсэгт хүүхдийг хүнд, хөнгөнөөр нь эрэмбэлэн ангилахад туслах хананы үзүүлэн, хүснэгт байрлуулсан байна.			

Эм, багаж, хэрэгсэл

Яаралтай тусламжид хэрэглэх зайлшгүй шаардлагатай эм, тариа (таталтын эсрэг, глюкоз, судсаар хийх шингэн) байнга, үнэ төлбөргүй байна.

Лабораторийн нэн шаардлагатай шинжилгээ (сахар, гемоглобин, гематокрит) хийх боломжтой, хариу нь цаг алдалгүй гарна.

Зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгсэл (зүү, тариур, хамар-амын гуурс, хүчилтөрөгчийн төхөөрөмж, өөрөө хийлэгдэх амьсгалын хүүдий, бүх хэмжээний хошуувч, цацагч, эсвэл түгээгч) бэлэн байна.

Ажиллах хүмүүс

Хүнд хөнгөнөөр эрэмбэлэн ангилах эмнэлгийн мэргэжилтэн байна.

Яаралтай тусламж авах шаардлагатай хэмээн үзсэн хүүхдэд цаг алдалгүй тусламж үзүүлэх эмнэлгийн мэргэжилтэн бэлэн байна.

Авах арга хэмжээ

Хүнд хөнгөнөөр эрэмбэлэн ангилах эмнэлгийн ажилтан эрэмбэлэн ангилах, яаралтай тусламж үзүүлэх удирдамжийн дагуу сургагдсан, яаралтай тусламжийн тасагт ачаалал ихдэх үед дээрх тусламжийг зохих ёсоор хэрэгжүүлэх чадвартай байна.

Тухайн тасгийнхан зонхилон тохиолдох яаралтай байдлын үед зөв зохистой арга хэмжээ авч, эмчилгээг цаг алдалгүй эхлүүлэх ур чадвар эзэмшсэн байна. Үүнд: таталт, ухаангүй байдал, амьсгал



гачаалын хүнд хэлбэр, шок эсвэл хүнд хэлбэрийн шингэн алдалтын үед үзүүлэх тусlamж орно.



3.4 Зайлшгүй шаардлагатай эм, багаж, хэрэгсэл

Дээрх хүснэгтээс харна уу. Хангамжийн байдлыг үнэлэхэд: хүчилтөрөгч, таталтын эсрэг зэрэг зайлшгүй шаардлагатай эм, тариа шууд хэрэглэхэд бэлэн байх ёстой бол антибиотик, бусад эмийн хувьд тасрахгүй гэсэн баталгаа байхад л хангалттай.

3.5 Яаралтай тохиолдлын эмчилгээ

Эх сурвалж: Мэдээллийг өвчтөнд ажиглалт хийх замаар цуглуулах бөгөөд ажилчидтай уулзаж өдөр тутмын үйл ажиллагааны талаар ярилцана. Ажиглалтыг нэгээс хоёр өвчтөнд хийх, боломжгүй бол таталт, амьсгалын гүн хямрал болон шоктой тохиолдлын зохиомжийг эмнэлгийн 2-3 ажилтанд танилцуулна.

Ажиглалтыг ажлын болон ажлын бус цагаар хийнэ. Яаралтай тохиолдол гарахгүй бол ажилчидтай уулзаж, тухайн тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар асууж ярилцана. Үүнд: таталттай, унтаарах, амьсгал гачаалын хүнд хэлбэртэй, хүнд шингэн алдалттай хүүхдэд авах арга хэмжээ орно.

Яаралтай тусlamжийн тасгийн нэгдсэн хүснэгт

	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
Яаралтай тусlamжийн тасгийн бүтэц, зохион байгуулалт.			
Орон тооны хангамж.			
Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж.			
Лабораторийн нэн шаардлагатай үйлчилгээний хангамж.			
Зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгслийн хангамж.			
Яаралтай тохиолдолд авах арга хэмжээ.			

Яаралтай тусlamж, үйлчилгээний нэгтгэсэн оноо (дугуйлах)	Сайн	Сайжруулах шаардлагатай				
	5	4	3	2	1	



4. Хүүхдийн тасаг

4.1 Зохион байгуулалт

Эх сурвалж: Тасгаар явах үеийн ажиглалт болон тасгийн эрхлэгч, ажилчид, өвчтөний сахиуруудтай хийх ярилцлага.

Тасаг хэдэн ортой вэ?

Одоо хэдэн өвчтөн хэвтэж байна вэ? Энэ нь хүүхдийн хэвтэлт өндөртэй улирал уу эсвэл бага улирал уу? Сүүлийн гурван жилд хэвтэх хүүхдийн тоо нэмэгдсэн үү?
Тайлбар хийнэ үү:

.....

.....

Хүүхдийн тасагт ямар насын хүүхдүүд хэвтэж эмчлүүлдэг вэ? ___ -ээс ___ нас Ариун цэврийн өрөө хаана байдаг вэ?

.....

Ариун цэврийн өрөө цэвэрхэн үү?

Тийм Үгүй

Орнууд аюулгүй, ажиллагаатай байдаг уу?

Тийм Үгүй

Ор гудастай юу?

Тийм Үгүй

Цагаан хэрэглэл олгодог уу?

Тийм Үгүй

Орнууд цэвэрхэн үү?

Тийм Үгүй

Хүүхдийн тасаг дотор юмуу эсвэл ойрхон яаралтай тусlamж авах газар бий юу?

Тийм Үгүй

Хүүхдийн тасагт дулаан үүсгэгч байдаг уу?

Тийм Үгүй

Ажиглалт болон тайлбар:

.....

.....

.....

.....

.....

4.2 Хүүхдийн тасгийн стандарт болон шалгуурууд


Стандартууд

- Амбулаторт хүүхдийн үзлэгийг зөвхөн хүүхдийн мэргэжлийн эмч хийнэ.
- Илүү хүнд хүүхдэд хамгийн их анхаарлыг хандуулдаг байна.
- Хүүхдэд зориулж тусдаа тасаг эсвэл өрөө байна.



- Өвчтэй нярай хүүхэд эхийн хамт байх тусдаа өрөөтэй.
- Эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээг зохих хэмжээнд хүргэж, эх, хүүхдийг байлгах нөхцөл бүрдүүлсэн байна.
- Ажилтнууд тасагт гараа угаах боломжтой, зүү тариурыг хаях сав байх.

Стандарт болон шалгуурууд	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
Амбулаторийн нөхцөлд хүүхдийн үзлэгийг зөвхөн мэргэжлийн эмч, зориулалтын өрөөнд хийх ёстой.			
Хүнд хүүхдэд түлхүү анхаарах.			
Илүү хүнд хүүхдүүдийг бүрэн хэмжээний анхаарал хандуулах хэсэгт байрлуулж эмчилнэ. Энэ хэсэг нь сувилагчийн постны хажууд байрлаж, хүүхдийг ихэнх цагаар шууд ажиглах боломж олгоно.			
Хүүхдэд зориулсан тусгай тасаг.			
Хүүхдүүд тусдаа тасаг эсвэл тасаг дотор зориултын хэсэгт байрлана. Хүнд хүүхдүүд халдварт болон эрчимт эмчилгээний зэрэг тасагт насанд хүрэгсдээс тусдаа байрлана. Мэс заслын эмгэгтэй хүүхдийг тусдаа байлгах бөгөөд хооллох, дулаан байлгах зэрэг тэдний өвөрмөц хэрэгцээг мэдэх эмнэлэгийн ажилтан хамт байна. Эдгээр хэрэгцээ шаардлагыг хангах арга хэмжээ авсан байна. Цаг агаарын хүйтэн нөхцөлд тасаг нь үр дүнтэй, аюулгүй дулааны эх үүсвэртэй байна.			



Өвчтэй нярай хүүхэд эхийн хамт байх тусдаа өрөө.

Өвчтэй нярай хүүхэд эрүүл нярайгаас тусдаа байна.
Өвчтэй хүүхдийн ээж нь хүүхэдтэйгээ хамт байх бөгөөд зохих хэрэгслээр хангагдсан байна.

Эрүүл ахуйн болон ослоос урьдчилан сэргийлэх

Ажилтнууд гараа угаах боломжоор хангагдсан, тасаг цэвэрхэн, хүүхдүүд аюултай зүйлсэд хүрэх боломжгүй байлгана.
Зүү тариурыг аюул ослоос сэргийлж тусгай хайрцаг, саванд хаяна.

Эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээг зохих хэмжээнд хүргэж, эх, хүүхдийг байлгах нөхцөл бүрдүүлнэ.

Шаардлага хангахуйц ариун цэврийн өрөө хүрэлцээтэй байна.
Эх, хүүхэд усанд орох боломжтой, гоожуурын устай өрөө тасагт ойрхон байна.
Эхэд өөрийн болон хүүхдийнхээ хувцасыг угаах газар олддог байна.
Хүүхдийн оп цэвэр гудастай байна.
Өвчтөнд орны цагаан хэрэглэл олгодог байна.

Хүүхдийн тасгийн үйл ажиллагааны нэгтгэсэн хүснэгт

	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тохиолдлуудын талаар тэмдэглэлүүд болон тайлбар
Хүүхдийн тасаг тусдаа байна.			
Өвчтэй нярай хүүхэд эхийн хамт тусдаа өрөөнд байна.			

	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тохиолдлуудын талаар тэмдэглэлүүд болон тайлбар
Эхчүүд, хүүхдэд зориулсан үйлчилгээний эрүүл ахуй хангалттай.			
Хамгийн их анхаарлыг илүү хүнд хүүхдэд тавина.			
Эрүүл ахуйн болон ослоос сэргийлэх арга хэмжээ авагдсан байна.			

Хүүхдийн тасгийн үйл ажиллагааны нэгтгэсэн оноо	Сайн	Сайжруулах шаардлагатай
(дугуйлах)	5	4

5. Зонхилон тохиолдох өвчиний үед авах арга хэмжээ:

- 5.1 Ханиалгах болон амьсгалах саадтай болох, хатгалгаа
- 5.2 Суулгалт;
- 5.3 Халуурах;
- 5.4 Хүнд тураал;

Эх сурвалж: Мэдээллийг холбогдох өвчин эмгэгтэй хүүхдийн эмчилгээ, асаргааг ажиглах болон эмнэлгийн ажилтан, сахиуруудаас асуумж авч цуглувна.

5.1 Ханиалгах болон амьсгал саадтай болох, хатгалгаа

Стандартууд

- Уушгинь хатгалгааг шинж тэмдгүүдэд тулгуурлан оношилж, ангилна.
- Шаардлагатай бол тохирсон антибиотик өгнө.
- Шаардлагатай бол хүчилтөрөгч өгнө.
- Цээжний рентген зураг авах зохих заалтыг мөрдөнө.
- Шуугиантай амьсгалтай хүүхдэд гуурсан хоолой тэлэгч эм цацлагаар зөв өгнө.
- Сүрьеэгийн эмчилгээг үндэсний удирдамжийн дагуу хийнэ.
- Хяналт болон дэмжих эмчилгээг зохих ёсоор хэрэгжүүлнэ.

Стандарт болон шалгуурууд	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
Уушгинь хатгалгааг үнэлэх			

Стандарт болон шалгуурууд	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
<p>Эрүүл мэндийн ажилтнууд уушгинь хатгалгааг зөв оношилж хүндийн зэргийг тогтоодог байна.</p> <p>Хүүхдийн биеийн ерөнхий байдал, хөхрөлт, амьсгалын тоо, цээж хонхолзох зэрэг шинжийг ажиглана.</p>			
Тохирох антибиотик өгөх			
<p>Ханиалгах болон амьсгал саадтай хүүхдэд шаардлагатай бол антибиотик өгнө (уушгинь хатгалгаа, уушгинь хүнд хатгалгаа, уушгинь маш хүнд хатгалгаа болон маш хүнд өвчнүүд).</p> <p>Уушгинь хатгалгаа байхгүй эсвэл антибиотик өгөх өөр шаардлага гарахгүй бол антибиотик өгөхгүй.</p>			
<p>Тохирох антибиотикийг уушгинь хатгалгааны хүндийн зэрэг болон жинг харгалзан зөв тунгаар өгнэ.</p>			
<p>Хэрвээ хүүхэд хоёр хоногийн дараа сайжрахгүй эсвэл биеийн байдал дордвол хүндрэл болон өөр өвчин бодно.</p>			
Хүчилтөрөгч эмчилгээ			
<p>Шаардлагатай бүх хүүхдэд хүчилтөрөгч эмчилгээ хийнэ.</p> <p>Хүчилтөрөгч шаардагдах эмнэлзүйн шинж (гипоксиемийн шинж) илрээгүй үед хүчилтөрөгч өгөхгүй.</p>			
<p>Хүчилтөрөгчийг зөв (хамрын ац гуурс эсвэл хамрын хаймсуураар, зөв урсалаар, тасралтгүй), хяналтан дор өгнө.</p> <p>Хүчилтөрөгчийн алдагдал өндөр, эрсдэл их тул хүчилтөрөгчийн маск болон майхан ашиглахаас зайлсхийнэ.</p>			

Стандарт болон шалгуурууд	Сайн	Сайжруулах шаардлагатай	Тайлбар
Цээжний рентген зураг авах			
<p>Уушгины хатгалгааны шинжүүд доорхи тохиолдолд илэрвэл цээжний зураг авна:</p> <p>Нялх хүүхдэд.</p> <p>Хүндрэл сэжигтэй үед (жишээ нь, уушгины эмпием, пневмоторакс, буглаа).</p> <p>> 48 цагаас дээш хугацаанд тохирох антибиотик авсан ч сайжрахгүй байгаа өвчтөнд.</p> <p>Уушгины хатгалгаа, ханиад шуухинаа хүндрээгүй үед тодорхой заалт байхгүй бол цээжний зураг авахгүй.</p>			
Шуугиантай амьсгал			
Гуурс тэлэгч өгөх хэрэгцээтэй хүүхдийг зөв тодорхойлсон байна.			
Гуурсан хоолой тэлэгч цацлагыг түгээгч болон цацагчаар зөв өгөх (арга, тун болон давтамж).			
